

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр

№ 24/27

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 24/04 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ-ийн 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зүгээс зах зээлд нэвтрүүлээд буй “Flexi Business” зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, нийгэмд ээлтэй, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг бизнес эрхлэгчдэд зээл олгох үйл ажиллагааг эрчимжүүлж буй бөгөөд энэ хүрээнд үүрэн холбооны 5 дахь оператор “ОНДО” ХХК-аас ирүүлсэн 1,500,000,000 (нэг тэрбум таван зуун сая) төгрөгийн зээлийн хүсэлтийг судалж, зээл олгох эсэх талаар шийдвэр гаргуулах хүсэлттэй танилцаад:

- “ОНДО” ХХК нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд болон Оюу Толгойд 4G/LTE сүлжээ байгуулж, дэд бүтэц бий болгосон, өдгөө 400,000 гаруй хэрэглэгчтэй бөгөөд цаашид дэд бүтэц, хэрэглэгчийн тоо нэмэгдэх боломжтойг харгалзан;
- “ОНДО” ХХК нь цаашид сансрын болон газрын хосолмол сүлжээг ашиглан өөрийн хэрэглэгчдэд огт сүлжээгүй газраас цахим зурвас, дуудлага илгээх, хүлээн авах үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж буйг харгалзан;
- Компанийн зүгээс “ОНДО” ХХК-д зээл олгох нь Компанийн Тогтвортой хөгжлийн бодлого (Нэгдсэн Үндэстний байгууллагаас тодорхойлсон Тогтвортой хөгжлийн 17 зорилго)-ын хүрээнд нийгэмд ээлтэй бөгөөд тогтвортой бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилготой нийцэх төдийгүй цаашид стратегийн хамтын ажиллагаа бий болгох боломжтойг тэмдэглэн;

“ОНДО” ХХК-д 1,500,000,000 (нэг тэрбум таван зуун сая) төгрөгийн бизнесийн зээлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсан нөхцөлийн дагуу олгохоор шийдвэрлэсүгэй.

2. “ОНДО” ХХК-тай энэхүү тогтоолын хавсралтаар баталсан нөхцөлийн дагуу Зээлийн гэрээ, “ОНДО Холдинг” ХХК-тай Барьцааны гэрээ тус тус байгуулах, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд байгуулсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, холбогдох бусад арга хэмжээ авах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр

№ 24/27

Улаанбаатар хот

- Энэхүү тогтоолын хэрэгжилтийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДВААЛТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр

№ 24/28

Улаанбаатар хот

2024 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.7 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 24/05 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ-ийн 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2024 оны санхүүгийн тайланд Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Шонхор Үнэлгээ Аудит” ХХК-ийг сонгосугай.
2. Компанийн дотоолын болон Олон улс дахь нэр хүнд, бизнесийн салбар дахь байр суурь, түүнчлэн Компанийн оролцогч нь болсон “АНД Глобал” группийн бусад компанид тавигддаг шаардлагын дагуу Компанийн 2024 оны санхүүгийн тайланд нэмэлтээр хөндлөнгийн аудит хийлгэх, ийнхүү хийлгэхдээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын байгууллагуудын нэг болох “Эрнет энд Янг Монголия Аудит” ХХК-тай хамтран ажиллах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. “Шонхор Үнэлгээ Аудит” ХХК болон “Эрнет энд Янг Монголия Аудит” ХХК-тай байгуулах холбогдох гэрээний нөхцөлүүдийг хэлэлцэн тохирох, тэдгээртэй гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
4. Хөндлөнгийн аудитын байгууллагуудыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл, боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт, материалыг гаргаж өгөх, тайланг төлөвлөсөн хугацаанд нийтлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БӨЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр

№ 24/29

Улаанбаатар хот

Бодлого шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 24/02, 24/03 тоот дүгнэлт болон ТУЗ-ийн 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ын зорилгод нийцүүлэн, Компанид засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээх, олон улсын стандартыг тухай бүрт нэвтрүүлэх зорилтын хүрээнд Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дор дурдсан бодлогуудыг шинэчлэн баталсугай:
 - 1.1. энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Эрсдэлийн удирдлагын бодлого”;
 - 1.2. энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар “Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн бодлого”.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэгдэн батлагдсан бодлогуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн нийт ажилтнуудад үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан бодлого, журмуудтай холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр

№ 24/30

Улаанбаатар хот

Бодлого батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын тодорхойлсон Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааныхаа бүхий л чиглэлд байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, засаглалын ёс зүйтэй байхыг хичээнгүйлэн ажиллаж, илүү тогтвортой, тэгш, хүртээмжтэй ирээдүйг бий болгоход хувь нэмрээ оруулах зорилгын хүрээнд Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх “Тогтвортой байдлын бодлого”-ыг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Тогтвортой байдлын бодлого”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн нийт ажилтнуудад үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан бодлоготой холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр

№ 24/31

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн сургалтын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)–ийн 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээний тайлангийн үүрэг даалгаврыг биелүүлэх ажлын хүрээнд Компанийн ТУЗ-ийн 2024 оны Сургалтын төлөвлөгөөг энхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
2. Энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр батлагдсан Компанийн ТУЗ-ийн 2024 оны Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж, сургалтыг зохион байгуулах, хамрагдсан сургалтын талаар Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнахыг Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд) д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР